

## НОБЕЛИЙН ШАГНАЛТНЫ 16 ДҮГНЭЛТ

Нобелийн шагнал бол Швед улсын инженер-химичин Альфред Бернхард Нобелийн (1833—1896) нэрэмжит олон улсын шагнал юм. Физик, хими, анагаах ухаан, физиологийн салбарт хийсэн гайхамшигт нээлт, утга зохиолын бүтээлд олгодог.

Нобелийн шагналтны 1989 оны ээлжит бага хурлаас дараа дурдсан арван зургаан дүгнэлт хийсэн юм. Үүнд:

1. Манай гариг дээрхи амьдралын бүх төрлийг хүн төрөлхтний гол өв мөн гэж үзвэл зохино. Иймээс экологийн тэнцвэр алдагдуулах нь ирээдүйн эсрэг гэмт хэрэг мөн.

2. Бид бүгдээр нэгэн төрөлд хамаарагдах бөгөөд энэ төрлийн төлөөлөгчдийн хувьд тус бүрдээ бусдын адил эрх чөлөө, тэгш байдал, нөхөрлөлийн тэгш эрх эдэлнэ.

3. Хүн төрөлхтний баялаг бол түүний олон янз байдагт оршино. Энэ олон янз байдлыг соёл, биологи, гүн ухаан, оюуны бүх хүрээнд хямгадан хамгаалбал зохино. Үүний тул тэсвэр гаргах, бусдыгаа сонсч чаддаг байх, үхширмэл номнол үл баримтлах зэрэг буянт үйлийг байнга үйлдэх хэрэгтэй.

4. Эдүгээ хүн төрөлхтний хэрэгжүүлэх хамгийн чухал асуудлууд нь түгээмэл, уялдсан шинжийг агуулж байна.

5. Шинжлэх ухааны мэдлэг бол эрх мэдлийн хэлбэр болсон учир тус тус хүмүүс ч гэсэн, ард түмэн ч гэсэн уг мэдлэгийг эзэмших адил боломжтой байх ёстой.

6. Олон оронд улстөрийн хүрээнийхэн ба шинжлэх ухааны хамтын нийгэмлэгийнхэн салангад байгааг гэтлэх нь чухал бөгөөд үүний тул хоёр тал нийгэмд тус тусын гүйцэтгэж байгаа үүргийг зөвшөөрөн хүлээх ёстой.

7. Боловсрол бүх улсуудын төсөвт үнэмлэхүй тэргүүлэх байр эзэлж бүх төрлийн бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц болох ёстой.

8. Шинжлэх ухаан техникийн ололт давын түрүүнд хөгжиж байгаа орнуудад хүртээмжтэй байж ирээдүйнхээ эзэн нь болж, хөгжихийн тул чухам ямар эрдэм мэдлэг хэрэгтэйг тодорхойлоход нь тус болох ёстой.

9. Ирээдүйд телевиз мэтийн олон түмний мэдээллийн хэрэгслүүд эрдэм мэдлэгийн үндсэн эх булгийн нэгэн болохыг харгалзан үзвэл сургалтын систем нь эдгээр сувгаар ирж байгаа мэдээлэлд шүүмжлэлтэй ханддаг болгоход түлхэц үзүүлэх ёстой.

10. Боловсрол, хэвийн хоол унд, өвчнөөс урьдчилан сэргийлэх явдал бол хүн амзүйн бодлогыг хөгжүүлэх үндсэн чиглэл бөгөөд хүүхдийн эндэгдлийг бууруулах хэрэгсэл мөн. Тухайлбал улстөрийн зүтгэлтнүүд, эрдэмтдийн нийтлэг зорилт нь одоо байгаа вакцинуудыг газар сайгүй дэлгэрүүлэн ашиглаж, шинийг боловсруулах явдал болох ёстой.

11. Дархлал хомсдлын хам шинж өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх салбарт судлаачдын тарамдуу байгаа чармайлтыг эмийн аж үйлдвэрийн тусламжтайгаар нэгтгэж аль болохоор урамшуулбал зохино. Боловсруулсан вакцинууд засгийн газруудаар сайшаагдах ёстой.

12. Молекулын биологийн салбарт гарсан сүүлчийн амжилтууд нь анагаах ухааныг хөгжүүлэх шинэ хэтийн төлөвийг нээж, зарим өвчний генетик механизмыг тогтооход тус боллоо. Эдгээр эмгэгээс урьдчилан сэргийлж, эмчилэн эдгэрүүлдэг болгохын тул энэ чигийн судалгааг газар сайгүй дэмжих нь зүйтэй.

13. Манай гаригийн нөөц нь хэмжээтэй бөгөөд түүний нэг хэсэг нь эдүгээ цэргийн хэрэгцээнд зориулагдаж байгаа тул зэвсэглэл хураах нь эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал түлхэц болно.

14. «Гуравдахь ертөнцийн» орнуудын эдийн засаг, улстөрийн хөгжлийг саатуулж байгаа гадаад өрийн бүх асуудлыг хэлэлцэх олон улсын бага хурал хуралдуулахыг бид уриалж байна.

15. Засгийн газрууд хүний эрхийг хүндэтгэх, өөрсдийн батласан хэлэлцээрийг биелүүлэх хатуу үүрэг хүлээх ёстой.

16. Нобелийн шагналтны бага хурал хоёр жилийн дараа эдгээр асуудлыг хэлэлцэхийн тул дахин хуралдана. Энэ хугацаанд нобелийн шагналтны бүлгүүд яаралтай оролцох шаардлагатай хямралт байдал бий болсон (Бхопаль\* буюу Чернобыльд нобелийн таван шагналтан очих юм бол их ач холбогдолтой байж болохыг бодоод үзэгтүн), эсхүл хүний эрх зөрчигдсөн газарт очиж шалгах болно.

«Курьер» сэтгүүлийн 1989 оны 6 дугаараас  
Г. Сүхбаатар орчуулав.

\* Бхопаль бол Энэтхэгийн хот бөгөөд тэнд байдаг америкийн химийн үйлдвэр дээр осол гарч хүмүүс амь үрэгдсэн юм.

### ЗҮҮН ХОЙТ АЗИ СУДЛАЛ № 1 (93)

Техник редактор Л. Сожилмаа  
Хянагч З. Эрдэнэчимэг

Оролтөнд 1993 оны 7 сард орж, Хэвлэлтэнд  
1993 оны 11 сард шилжин 500 хувь хэвлэв.  
Цаасны хэмжээ 70x100/16, хх 3, хнх 3,87 За № 24

ШУХэвлэлийн «Эрдэм» компанид хэвлэв.  
Нэгдсэн Үндэстний гудамж-19, Улаанбаатар хот